



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/229

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулсан ажлын хэсэг “Сэлэнгэ орон сууц” ХХК, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцан, Хэнтий аймагт хэрэгжүүлэх талаар санал боловсруулах зорилгоор Сэлэнгэ аймагт ажиллахад зориулж 1,899,200 (нэг сая найман зуун ерэн есөн мянга хоёр зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохисон байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 22-ны өдрийн
2022 захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Шатахуун	1700км=340л	3,380	1,149,200
2	Томилолт (Сэлэнгэ)	5хүн (3 хоног)	50,000	750,000
Дүн				1,899,200